

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2010 оны 6 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 207

Улаанбаатар хот

Г Бүртгэлийн гэрчилгээний загвар 7 батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, 23.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2010 оны 97 дугаар тогтоолоор батлагдсан “Зэрэглэл тогтоох этгээдэд эрх олгох, үйл ажиллагааг бүртгэх журам”-д заасан эрхийг авч, үйл ажиллагаагаа бүртгүүлсэн хуулийн этгээдэд Санхүүгийн зохицуулах хорооноос олгох бүртгэлийн гэрчилгээний загварыг хавсралтаар баталсугай.

2. Бүртгэлийн гэрчилгээг батлагдсан загварын дагуу хэвлүүлж, эрх авсан хуулийн этгээдэд олгоход бэлэн болгохыг Тамгын газар /Н. Удаанжаргал/-т даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН



МОНГОЛ УЛС

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар ...

... оны ... дугаар сарын ...-ны /ний/ өдөр

Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны 2010 оны 97 дугаар тогтоол болон бусад хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул Санхүүгийн зохицуулах хорооны _____ оны ____ сарын ____ өдрийн _____ дугаар _____ тогтоолоор

Д

үйл ажиллагааг бүртгэн энэхүү гэрчилгээг олгов.

ДАРГА /гарын үсэг/

“Тэмдэг”

*Энэхүү гэрчилгээ
нь хавсралтын
хамт хүчинтэй*



МОНГОЛ УЛС

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

_____ ТООТ

БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ХАВСРАЛТ

“Тэмдэг”

Хуулийн этгээдэд зэрэглэл тогтоох байгууллагад зориулсан тэмдэглэл

(Энэхүү хавсралт нь бүртгэлийн гэрчилгээний хамт хүчинтэй)

Нэг. Хуулийн этгээдийн оноосон нэр:

Хоёр. Хуулийн этгээдийн хаяг, хаягийн өөрчлөлтийн тэмдэглэл:

Д/д	Хаяг	Утас, факс, и-мэйл хаяг	Тэмдэглэл хийсэн огноо, тэмдэг

Гурав. Дүрмийн сангийн өөрчлөлтийн тэмдэглэл:

Д/д	Дүрмийн сангийн нэмэгдүүлсэн, хорогдуулсан хэмжээ	Зөвшөөрөл олгосон огноо	Зөвшөөрөл олгосон шийдвэрийн дугаар	Дүрмийн сангийн хэмжээ

Дөрөв. Хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүний талаар:

